



**ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 03

Чингис хот

Нөөцийн сангаас нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.8, 2.3, 2.3.5, 2009 оны 99 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 6.1, 6.2, 6.2.2-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2017 оны 15 дугаартай тогтоолоор төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн Энхбаатарын Мягмарсүрэнг Бэрх хотын Захирагчийн ажлын албаны дотоод ажил, мэдээлэл сурталчилгаа хариуцсан түшмэлийн сул ажлын байранд санал болгосугай.

2. Э.Мягмарсүрэнг сул ажлын байранд томилсон шийдвэрийг 2018 оны 01 дүгээр сарын 20-ны дотор хүлээн авч танилцуулахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Болормаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР